


ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
ДАРГА *[Signature]* С.Ч. ЧАНЦАЛДИЙМАА



ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2025 оны 06-р сарын 15 -ны өдөр

№.....

Улаанбаатар хот

Нэг талаас "МУ-ын иргэн Д.Дуламсүрэн" /цаашид худалдагч гэх/, нөгөө талаас "Өвөрхангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв" /цаашид худалдан авагч гэх/-ийг төлөөлж инженер албан тушаалтай Ч.Очирбат нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож, зөвшилцсөнөөр энэхүү гэрээ байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гэрээний нөхцлийн дагуу худалдагч биет байдлын болон эрхийн доголдолгүй **Хавсралт-1-д** заасан бүтээгдэхүүнүүдийг холбогдох бичиг баримт /цаашид "Бараа" гэх/-ийн хамт худалдан авагчид нийлүүлэх, худалдан авагч барааг хүлээн аван төлбөрийг төлөхгүй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Баталгаат хугацаа: 1 жилийн баталгаат хугацаа өгөх ба энэхүү хугацааны дотор гарсан худалдан авагчаас үл шалтгаалсан эвдрэл, гэмтэл, согогийг ажлын 7 өдрийн дотор үнэ төлбөргүй засах үүргийг худалдагч тал хүлээнэ. Худалдан авагчийн буруугаас үүссэн механик гэмтэл болон системийн гэмтэл үүнд хамаарахгүй.
- 1.3. Худалдан авч буй бараа болгонд байгууллагын лацыг наах бөгөөд лацыг хөндсөн тохиолдолд баталгаат хугацаа хүчингүй болно.
- 1.4. Гэрээний хугацаа: Энэхүү гэрээний хугацаа нь барааг хүлээлгэн өгч, нэхэмжилсэн барааны төлбөр 100% төлөгдсөнөөр дуусгавар болно.

Хоёр. Төлбөр

- 2.1. Нийт гэрээний үнийн дүн **15000000₮ /арван таван сая /** төгрөг байна.
- 2.2. Худалдан авагч бэлэн байгаа барааны төлбөрийн шилжүүлэн барааг авах ба захиалгын барааны төлбөрийг бараа хүлээн авсны дараа 3 хоногийн дотор худалдагчийн **Голломт банкны 1105082271** тоот дансанд шилжүүлнэ төлбөрийг дуусгавар болгоно.
- 2.3. Төлбөр хугацаа хоцорсон тохиолдолд хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5%-аар алданги төлнө.

Гурав. Худалдагчийн эрх, үүрэг

- 3.1. Гэрээний хавсралтад заасан чанар, үзүүлэлт бүхий барааг гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш ажлын 3 хоногийн дотор нийлүүлэх;
- 3.2. Барааг хүлээлгэн өгөхдөө худалдан авагчид дагалдах бичиг баримтын хамт шалгуулж, гарын үсэг зуруулан актаар хүлээлгэн өгөх;
- 3.3. Баталгаат хугацаанд гарсан аливаа доголдлыг 1.2-т заасан хугацааны дотор засварлах, солих;
- 3.4. Худалдан авагчаас төлбөрөө төлөхийг шаардах;

Дөрөв. Худалдан авагчийн эрх, үүрэг

- 4.1. Барааг хүлээж авахдаа хавсралтад заагдсан үзүүлэлт, чанар, нэг бүрдлийг шалгаж, дагалдах бичиг, баримтын хамт хүлээн авч акт үйлдэнэ;
- 4.2. Барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаандаа шилжүүлэх;

- 4.3 барааг хугацаандаа нийлүүлэхийг худалдагч талаас шаардах;
4.4 Барааг шалгах, ашиглах явцад илэрсэн доголдлыг тухай бүр мэдэгдэх;
4.5 Худалдан авагч нь хүлээн авсан барааны лац, ломбыг хөндөхгүй байх;
4.6 Худалдагчаас гэрээний хавсралтад дурьдсан чанар, үзүүлэлттэй бараа нийлүүлэх доголдлыг гэрээнд заасан хугацаанд арилгахыг шаардах;



Тав. Хариуцлага

- 5.1 Талууд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан бодит хохирлыг буруутай тал бүрэн хариуцаж төлнө.
5.2 Гэрээний хавсралтад заагдсан барааг худалдан авагчид нийлүүлээгүй тохиолдолд үл маргах журмаар хавсралтад дурьдсан бараагаар сольж өгөх, үүнтэй холбогдон гарах бүх зардлыг худалдагч тал бүрэн хариуцна.
5.3 Худалдагч тал төлбөрийн мөнгийг хүлээн авсан боловч барааг нийлүүлээгүй бол барааны үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг хугацаа хэтэрсэн хоног тутмаар тооцож худалдан авагчид төлнө.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.
6.2 Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйлүүд

- 7.1 Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа шууд мэдэгдэнэ.
7.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

Найм. Бусад

- 8.1 Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.
8.2 Талууд харилцан зөвшилцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.
8.3 Энэхүү гэрээний хавсралт мөн гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧ:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Хаяг: Өвөрхангай Арвайхээр сум

Утас: 90053338

Худалдан авагчийг төлөөлж:

Ч. Очирбат

ХУДАЛДАГЧ:

“МУ-ЫН ИРГЭН”

Хаяг: Баянгол дүүрэг 1 хороо Богда-ар
хороолол 1А байр 46 тоот

Утас : 88009788

Худалдагчийг төлөөлж:

Д.Дуламсүрэн

НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮНИЙН САНАЛ



№	Барааны нэр	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийлүүлэх хугацаа
1	Visalia-гийн автомат хурын хувин, холбогдох кабел	2	7500.000	15000.000	1-7 хоног
НИЙТ ҮНЭ (нөат багтсан)				15000.000	

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧ:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Хаяг: Өвөрхангай Арвайхээр сум

Утас: 90053338

Худалдан авагчийг төлөөлж:

Ч. Очирбат

ХУДАЛДАГЧ:

“МУ-ЫН ИРГЭН”

Хаяг: Баянгол дүүрэг 1 хороо Богда-ар
хороолол 1А байр 46 тоот

Утас : 88009788

Худалдагчийг төлөөлж:



Д.Дуламсүрэн